



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2025/109/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2025 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас:70373089, 99023682

Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас:99023682

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас:99377479

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Захирал: Б.Жаргалсайхан

Утас:99862066

Цахим хаяг:peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 18 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.МАЙЦЭЦЭГ ТАНАА

2025.02.25 № 123

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 8 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 38.7 хувиар өссөн байна.

4525026202

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 79 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 72.5 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>318,851,119.34</b>	<b>418,796,519.66</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>254,469,145.10</b>	<b>324,996,610.52</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	254,469,145.10	324,996,610.52
31210	Төгрөг	254,469,145.10	324,996,610.52
31211	Төрийн сангийн харилцах	254,469,145.10	324,996,610.52
33	<b>АВЛАГА</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>64,381,974.24</b>	<b>93,799,909.14</b>
35100	<b>Түүхий эд материал</b>	<b>1,323,130.00</b>	<b>1,409,540.00</b>
35130	Эм боох материал	1,323,130.00	1,409,540.00
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>63,058,844.24</b>	<b>92,390,369.14</b>
35410	Бичиг хэргийн материал	3,227,100.00	2,607,100.00
35420	Аж ахуйн материал	8,768,706.18	15,405,213.18
35470	Бусад хангамжийн материал	51,063,038.06	74,378,055.96
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	-	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,679,603,257.91</b>	<b>3,516,917,115.86</b>
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,679,603,257.91</b>	<b>3,516,917,115.86</b>
39100	Газар	-	-
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,863,578,257.87</b>	<b>2,702,267,115.78</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,534,911,736.48	2,534,911,736.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(393,122,515.38)	(470,702,913.42)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	428,995,779.36	500,072,893.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,785,022.06)	(192,950,800.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	275,997,773.08	297,311,466.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(58,847,537.36)	(112,510,203.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	196,250,745.84	196,250,745.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(65,224,566.52)	(84,655,956.76)
39217	Ном	43,401,864.43	34,540,148.09
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>816,025,000.04</b>	<b>814,650,000.08</b>
39301	Програм хангамж	13,243,936.00	13,243,936.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,118,935.96)	(10,493,935.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	811,900,000.00	811,900,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,998,454,377.25</b>	<b>3,935,713,635.52</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,998,454,377.25</b>	<b>3,935,713,635.52</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,998,454,377.25</b>	<b>3,935,713,635.52</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,543,556,279.24	1,543,556,279.24
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,543,556,279.24	1,543,556,279.24
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(460,845,695.72)</b>	<b>(523,586,437.45)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(918,438,564.92)	(460,845,695.72)
51220	Тайлант үеийн үр дүн	457,592,869.20	(62,740,741.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,915,743,793.73	2,915,743,793.73
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,998,454,377.25</b>	<b>3,935,713,635.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,981,883,768.80	3,333,998,751.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	397,076,168.80	68,409,451.80
120	Нийтлэг татварын бус орлого	397,076,168.80	68,409,451.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,292,098.00	27,657,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,922,000.00	10,830,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,370,098.00	16,827,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	347,126,018.40	17,238,179.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,658,052.40	23,514,272.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,584,807,600.00	3,265,589,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,529,256,300.00	3,167,933,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,529,256,300.00	3,167,933,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,551,300.00	97,655,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,551,300.00	97,655,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,524,290,899.60	3,383,563,604.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,523,153,692.32	3,383,563,604.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,358,784,852.32	3,187,499,294.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,755,355,071.35	2,433,903,882.00
210101	Үндсэн цалин	1,156,710,507.35	1,528,452,289.00
210102	Нэмэгдэл	525,294,598.00	783,306,242.00
210104	Урамшуулал	333,000.00	122,145,351.00
210105	Гэрээт ажлын хөлс	73,016,966.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,731,200.00	291,309,400.00
210201	Тэтгэврийн даатгал	156,200,900.00	190,358,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,866,800.00	25,362,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,121,800.00	12,631,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,059,600.00	12,631,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,482,100.00	50,325,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,744,792.72	53,513,490.37
210301	Гэрэл, цахилгаан	16,859,669.47	20,760,073.42
210302	Түлш, халаалт	27,664,057.78	26,649,026.36
210303	Цэвэр, бохир ус	4,221,065.47	6,104,390.59
2104	Хангамж, бараа материалын зардал	34,956,868.00	25,131,333.20
210401	Бичиг хэрэг	4,795,048.00	8,414,030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,722,075.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,439,745.00	16,717,303.20
2105	Нормативт зардал	1,195,270.00	525,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,195,270.00	525,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,795,797.00	29,823,420.00
210604	Урсгал засвар	27,795,797.00	29,823,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,467,168.55	27,833,946.84
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,467,168.55	27,833,946.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,538,684.70	325,457,882.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,928,462.00	49,464,185.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,937,899.20	23,992,764.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	184,672,323.50	252,000,932.71

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,368,840.00	196,064,309.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	164,368,840.00	170,495,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,767,000.00	154,974,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,601,840.00	15,521,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,137,207.28	25,569,109.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,569,109.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	457,592,869.20	(49,564,852.69)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,175,889.04
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	13,175,889.04
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	457,592,869.20	(62,740,741.73)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,599,962,490.72	3,293,246,300.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,292,098.00	27,657,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,292,098.00	27,657,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,292,098.00	27,657,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,922,000.00	10,830,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,370,098.00	16,827,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,583,670,392.72	3,265,589,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,529,256,300.00	3,167,933,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,529,256,300.00	3,167,933,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,414,092.72	97,655,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,414,092.72	97,655,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,309,100,762.62	3,137,466,334.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,309,100,762.62	3,137,466,334.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,144,731,922.62	2,941,402,024.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,755,355,071.35	2,433,903,882.00
210101	Үндсэн цалин	1,156,710,507.35	1,528,452,289.00
210102	Нэмэгдэл	525,294,598.00	783,306,242.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	333,000.00	-
210104	Урамшуулал	73,016,966.00	122,145,351.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,731,200.00	291,309,400.00
210201	Тэтгэврийн даатгал	156,200,900.00	190,358,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,882,400.00	25,362,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,106,200.00	12,631,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,776,500.00	12,631,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,765,200.00	50,325,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,744,792.72	53,513,490.37
210301	Гэрэл, цахилгаан	16,859,669.47	20,760,073.42
210302	Түлш, халаалт	27,664,057.78	26,649,026.36
210303	Цэвэр, бохир ус	4,221,065.47	6,104,390.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,080,000.00	25,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	580,000.00	838,500.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	24,561,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,891,568.55	37,184,352.58
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,891,568.55	37,184,352.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,929,290.00	100,090,900.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,851,842.00	71,436,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,077,448.00	28,654,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>164,368,840.00</b>	<b>196,064,309.63</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>164,368,840.00</b>	<b>170,495,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,767,000.00	154,974,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,601,840.00	15,521,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>25,569,109.63</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,569,109.63
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>290,861,728.10</b>	<b>155,779,965.42</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>65,134,800.00</b>	<b>85,252,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>65,134,800.00</b>	<b>85,252,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>65,134,800.00</b>	<b>85,252,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,134,800.00	85,252,500.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(65,134,800.00)</b>	<b>(85,252,500.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	-
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	-	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>225,726,928.10</b>	<b>70,527,465.42</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,742,217.00	254,469,145.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	254,469,145.10	324,996,610.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(918,438,564.92)	3,540,861,508.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(918,438,564.92)	3,540,861,508.05
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	457,592,869.20	457,592,869.20
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(460,845,695.72)	3,998,454,377.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(460,845,695.72)	3,998,454,377.25
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(62,740,741.73)	(62,740,741.73)
				(523,586,437.45)	3,935,713,635.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,544,690,800.00</b>	<b>3,197,149,724.95</b>	<b>(347,541,075.05)</b>	<b>90.2</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,544,690,800.00</b>	<b>3,111,897,224.95</b>	<b>(432,793,575.05)</b>	<b>87.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,358,965,500.00</b>	<b>2,941,402,024.95</b>	<b>(417,563,475.05)</b>	<b>87.6</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,647,459,500.00</b>	<b>2,433,903,882.00</b>	<b>(213,555,618.00)</b>	<b>91.9</b>
210101	Үндсэн цалин	1,833,559,400.00	1,528,452,289.00	(305,107,111.00)	83.4
210102	Нэмэгдэл	730,033,300.00	783,306,242.00	53,272,942.00	107.3
210104	Урамшуулал	83,866,800.00	122,145,351.00	38,278,551.00	145.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>330,932,400.00</b>	<b>291,309,400.00</b>	<b>(39,623,000.00)</b>	<b>88.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	225,034,000.00	190,358,000.00	(34,676,000.00)	84.6
210202	Тэтгэмжийн даатгал	26,474,600.00	25,362,900.00	(1,111,700.00)	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,237,300.00	12,631,400.00	(605,900.00)	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	13,237,300.00	12,631,400.00	(605,900.00)	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	52,949,200.00	50,325,700.00	(2,623,500.00)	95.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>77,007,600.00</b>	<b>53,513,490.37</b>	<b>(23,494,109.63)</b>	<b>69.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,581,400.00	20,760,073.42	1,178,673.42	106.0
210302	Түлш, халаалт	49,382,400.00	26,649,026.36	(22,733,373.64)	54.0
210303	Цэвэр, бохир ус	8,043,800.00	6,104,390.59	(1,939,409.41)	75.9
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,510,000.00</b>	<b>25,400,000.00</b>	<b>(7,110,000.00)</b>	<b>78.1</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	838,500.00	838,500.00	-
210602	Тавилга	7,110,000.00	-	(7,110,000.00)	-
210604	Урсгал засвар	25,400,000.00	24,561,500.00	(838,500.00)	96.7
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>68,749,300.00</b>	<b>37,184,352.58</b>	<b>(31,564,947.42)</b>	<b>54.1</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,749,300.00	37,184,352.58	(31,564,947.42)	54.1
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>202,306,700.00</b>	<b>100,090,900.00</b>	<b>(102,215,800.00)</b>	<b>49.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	173,652,200.00	71,586,400.00	(102,065,800.00)	41.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,654,500.00	28,504,500.00	(150,000.00)	99.5
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>185,725,300.00</b>	<b>170,495,200.00</b>	<b>(15,230,100.00)</b>	<b>91.8</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>185,725,300.00</b>	<b>170,495,200.00</b>	<b>(15,230,100.00)</b>	<b>91.8</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	170,204,100.00	154,974,000.00	(15,230,100.00)	91.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,521,200.00	15,521,200.00	-	100.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>85,252,500.00</b>	<b>85,252,500.00</b>	<b>-</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>85,252,500.00</b>	<b>85,252,500.00</b>	<b>-</b>
223001	Бусад хөрөнгө	-	85,252,500.00	85,252,500.00	-

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,544,690,800.00</b>	<b>3,267,677,190.37</b>	<b>(277,013,609.63)</b>	<b>92.2</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,167,933,700.00</b>	<b>3,167,933,700.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,167,933,700.00	3,167,933,700.00	-	100.0
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>98,007,600.00</b>	<b>72,086,490.37</b>	<b>(25,921,109.63)</b>	<b>73.6</b>
132001	Орон нутгийн төсвөөс	98,007,600.00	72,086,490.37	(25,921,109.63)	73.6
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>278,749,500.00</b>	<b>27,657,000.00</b>	<b>(251,092,500.00)</b>	<b>9.9</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,610,000.00	10,830,000.00	220,000.00	102.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,400,000.00	16,827,000.00	2,427,000.00	116.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	253,739,500.00	-	(253,739,500.00)	-
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>254,469,145.10</b>	<b>254,469,145.10</b>	<b>-</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>324,996,610.52</b>	<b>324,996,610.52</b>	<b>-</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610002	Төсвөөс гадуур байгууллага	1.00	1.00	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>90.00</b>	<b>90.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	76.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>1,338.00</b>	<b>1,351.00</b>	<b>13.00</b>	<b>101.0</b>
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>1,338.00</b>	<b>1,351.00</b>	<b>13.00</b>	<b>101.0</b>
630001	Төрийн өмчит ЕБС	1,338.00	1,351.00	13.00	101.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургууль нь сурлагын хоцрогдлыг арилгах, сурах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, суралцагчдын бие даан суралцах чадварыг хамтын оролцоотойгоор хөгжүүлнэ гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургууль нь Дархан сумын 4 дүгээр багийн харьяа 6 наснаас дээш хүүхдүүдэд бүрэн дунд боловсрол олгох боловсролын үйлчилгээг бүрэн хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;

- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд Нягт Гүйцэтгэл ХХК-ний боловсруулсан 2022 оны 01 сарын 02 өдрийн захирлын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62,740.74 мянган төгрөгөөр буюу 1.57 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	254,469.2	324,996.6	70,527.5
Авлага	-	-	-
Бараа материал	64,382.0	93,799.9	29,417.9
Үндсэн хөрөнгө	3,679,603.3	3,516,917.1	(162,686.1)
Нийт хөрөнгө	3,998,454.4	3,935,713.6	(62,740.7)
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Эздийн өмчийн дүн	3,998,454.4	3,935,713.6	(62,740.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,998,454.4	3,935,713.6	(62,740.7)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 324,996.6 мянган төгрөг болж өмнөх оноос 70,527.5 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар

төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 93,799.9 мянган төгрөг болж 29,417.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 85,177.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 23,514.3 мянган төгрөгийн бага болон ахлах ангиудад цахим ном сурах бичиг, тусгай хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй хүлээн авч, 79,273.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 162,686.1 мянган төгрөг болж буурсан байна. Тодруулбал Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 9,656.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,267.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,314.2 мянган төгрөгийн ном сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэн, урсгал төсвийн хүрээнд боловсролын шинэчлэлийн бодлогын дагуу тоног төхөөрөмж, цахим кабинет байгуулах, нөхөн хангалтын зардалыг санхүүжилтыг зарцуулах журмын хүрээнд тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авсан 91,038.2 мянган төгрөг нийт 108,276.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох тушаал шийдвэрүүдийг үндэслэн холбогдох дансуудад тус тус бүртгэсэн, Аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 03 ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 18,961.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасаж тайлан тодруулгад тусгасан байна. Тайлант хугацаанд 252,000.9 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,935,713.6 мянган төгрөг болж 62,740.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургууль нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,726,211.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 98,955.1 мянган төгрөг, нийт зарлагыг 2,825,166.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 226,983.5 мянган төгрөгөөр бууруулж 2,499,227.5 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 12,047.5 мянган төгрөгөөр бууруулж 86,907.6 мянган төгрөг, нийт 2,586.135.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 668,706.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийг 11,100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,167,933.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 98,007.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,610.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 14,400.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 253,739.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 3,544,690.8 мянган төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,167,933.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 97,655.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,830.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 16,827.0 мянган төгрөг нийт 3,293,246.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 3,197,149.7 мянган төгрөг буюу 90.2 хувьтай зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 25,569.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	80111	Тогтмол зардал	102,407.6	78,913.5	(23,494.1)	77.1
2	80226	Байр ашиглалт үйлчилгээ	7,163.7	7,163.7	0.0	100.0
3	80233	Хүүхэд хамгаалал	7,402.0	7,402.0	0.0	100.0
4	80312	Сургалт семинарын зардал	5,198.9	3,632.4	(1,566.5)	69.9
5	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	16,088.4	3,807.4	(12,281.1)	23.7
6	81801	Үдийн цай хөтөлбөр	170,204.1	154,974.0	(15,230.1)	91.1
7	81816	Хүүхдэд ээлтэй орчин	53,866.6	53,866.6	0.0	100.0
8	81823	Багшийн мэргэжил дээшлүүлэх зардал	23,889.8	9,920.0	(13,969.8)	41.5
9	81834	Боловсролын стандарт	3,008,671.2	2,738,276.8	(270,394.4)	91.0
10	81835	Сургалт хэвийн үйл ажиллагаа хангах	114,954.1	111,764.1	(3,190.0)	97.2
11	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	10,743.2	10,460.9	(282.3)	97.4
12	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр	14,101.2	6,968.4	(7,132.8)	49.4
13	83603	Нэмэлт дээд шатнаас хуваарилсан	10,000.0	10,000.0	0.0	100.0
Нийт дүн			3,544,690.8	3,197,149.7	(347,541.1)	90.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж,

чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 2,523,153.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 50,463.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаас дээш төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, 54,134.1 мянган төгрөгийн 6 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 5,128.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	86.8	1	86.8	100
Зөвлөмж	3	5,041.6	3	5,041.6	100

/мянган төгрөгөөр/

Нийт дүн	4	5,128.4	4	5,128.4	100
----------	---	---------	---	---------	-----

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,906.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 923.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6,983.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөрчилд зөвлөмж өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллага дээд шатны албан тушаалтны шийдвэргүйгээр төсвийн шууд захирагчид 280,800.00 төгрөгийн спортын мастерын нэмэгдэл, сургуулийн захирлын тушаал шийдвэргүй болон тушаалд заасан хувь хэмжээнээс илүү тооцож 642,900.00 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл нийт 923.7 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дугаар хамтарсан тушаалын 8 дахь "Багш ажилтанд ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

Сургуулийн захирал, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 6,983.2 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### 5.3 Зөвлөмж

1. Тус сургууль нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3. "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Шилэн данстай холбоотой зөвлөмжийг тайлангийн 4.4.1 дэх хэсэгт тусгасан болно.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	54,134.1					1	54,134.1
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>54,134.1</b>					<b>1</b>	<b>54,134.1</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын санг байгуулах	1						1	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>54,134.1</b>					<b>2</b>	<b>54,134.1</b>



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/62-24010611-2111-2025/09/1111-СДН-ТӨС Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тус байгууллага дээд шатны албан тушаалтны шийдвэргүйгээр төсвийн шууд захирагчид 280,800.00 төгрөгийн спортын мастерын нэмэгдэл, сургуулийн захирлын тушаал шийдвэргүйгээр болон тушаалд зааснаас илүү хувь хэмжээгээр тооцож 642,900.00 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тус тус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10,9 дугаар хамтарсан тушаалын 8 дахь "Багш ажилтанд ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

4525050184

1. Илүү олгосон 923,700.00 /есөн зуун хорин гурван мянга долоон зуун/ төгрөгийг хавсралтад дурдсан ажилтан нараар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сургуулийн захирал Н.Майцэцэг, нягтлан бодогч Ц.Дэлгэрмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ПИЙК ОМ АУДИТ ХХК-НИЙ АУДИТОР



А.БАТБОЛД

**ТӨЛБӨРИЙН АКТ ХҮЛЭЭН АВСАН:**

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН

18 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Н.МАЙЦЭЦЭГ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



9022805  
4627143825

Ш.МӨНХБАЯР



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 02 сар 25 өдөр

Дугаар 01/59-24010611-211-2025/109/1111-СГА-Т113 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын 18 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургуулийн захирал, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 6,983,200.00 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ...." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж, мөнгөн урамшуулал давхардуулан олгох зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 18 дугаар сургуулийн захирал Н.Майцэцэг, нягтлан бодогч Ц.Дэлгэрмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.БАТБОЛД



4525040177